



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 044

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хангалт үйлчилгээний ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 68,303,000.00 (жаран найман сая гурван зуун гурван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 2 дахь дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Хангалт үйлчилгээний ангийн захирагч С.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001500



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн  
РХУ... дугаар тогтоолын хавсралт

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Хангалт үйлчилгээний ангийн  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, сэлбэгээр худалдах автомашин, механизмдын жагсаалт

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Сэлбэгээр ашигласнаас олох орлогын хэмжээ (төгрөг)
1	Комаци, 66-16 УБ, тусгай, 1023	1985/2012	196994	20,000,000.00	20,000,000.00	0	0	500,000.00
2	Хьюндай грейс, 80-52 УБР, суудлын, 81860648, 511455	2001/2001	300926	17,640,000.00	17,640,000.00	0	0	200,000.00
3	Прадо-95, 12-28 ОВА, суудлын, хөдөлгүүр-1490304, арал-RZJ95-0006973	1997/2008	196994	18,000,000.00	18,000,000.00	0	0	200,000.00
4	ЗИЛ130 ТСВ6, 60-07 НАА, тусгай, хөдөлгүүр-156198, арал-3382694	1993/1995	360000	12,663,000.00	12,663,000.00	0	0	200,000.00
	<b>Нийт дүн</b>			<b>68,303,000.00</b> (жаран найман сая гурван зуун гурван мянган)	<b>68,303,000.00</b> (жаран найман сая гурван зуун гурван мянган)	<b>0</b>	<b>0</b>	<b>1,100,000.00</b> (нэг сая нэг зуун мянган)